

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ  
ЦАХИАГИЙН ЭЛБЭГДОРЖИЙН  
ШАНХАЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮН ОРНУУДЫН ТӨРИЙН  
ТЭРГҮҮН НАРЫН ЗӨВЛӨЛИЙН  
ХУРАЛДААНД ХЭЛСЭН ҮГ**

Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч эрхэмсэг ноён Алмазбек Атамбаев, хуралдаанд оролцож буй улс орнуудын тэргүүн, олон улсын байгууллагуудын төлөөлөгчдийн тэргүүн нар аа, Хатагтай, ноёд оо,

Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын даргын хүндтэй албыг амжилттай хашиж, тус байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн ээлжит хуралдааныг эх нутагтаа зохион байгуулан, төлөөлөгч биднийг халуун дотноор хүлээн авч буй Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч эрхэм хүндэт Алмазбек Шаршенович Танд гүн талархлаа илэрхийлье. Монгол түмний элгэмсэг дотно анд, түүх, соёлын эртний хэлхээ холбоотой Киргиз түмний эх нутагт зочилж байгаадаа миний бие туйлын баяртай байна. Өнгөрч буй нэг жилийн хугацаанд Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хүрээндбүс нутгийн аюулгүй байдал, эдийн засаг, соёл боловсрол зэрэг бүх талын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд Киргиз нөхөд маань идэвх зүтгэл гарган, жинтэй хувь нэмрээ орууллаа.

Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутагт өрнөж буй улс төр, эдийн засгийн олон талт үйл явцад идэвхтэй, үр бүтээлтэй оролцохыг эрмэлздэг. Тиймээс Төв Азийн бүс нутагт тогтвортой, аюулгүй байдлыг хангах, эдийн засаг болон бусад салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх механизм болон төлөвшиж буй Шанхайн хамтын ажиллагааны байгууллагыг Монгол Улс тус бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцох нэгчухал хэмээн үзэж, өндөр ач холбогдол өгч ирсэн. ШХАБ-ын дээд төвшний уулзалтад Монгол Улсын төрийн тэргүүн 7 удаа оролцож байна. ШХАБ бөгөөд тус байгууллагын гишүүн, ажиглагч, яриа хэлцээний түнш орнуудтай харилцаагаа идэвхтэй хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж байгаа болно.

Монгол Улс ШХАБ-ын хүрээнд эдийн засаг, соёл, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хохирлыг бууруулах зэрэг олон салбарт хамтран ажиллах

сонирхолтой байдаг. Өнгөрсөн 2012 оны 12 дугаар сард Бишкек хотноо болсон ШХАБ-ын гишүүн орнуудын Засгийн газрын Тэргүүн нарын зөвлөлийн хуралдаанаар батлагдсан “2012-2016 онд ШХАБ-ын хүрээн дэх төслийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний жагсаалт”-д анхаарал хандуулж, зарим төсөлд зохистой хэлбэрээр оролцохыг хүсч байна. ШХАБ-ын Эрчим хүчний клуб, ШХАБ-ын хүнсний аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм болон Онцгой байдлын үр дагаврыг арилгах, урьдчилан сэргийлэх ШХАБ-ын төв байгуулах чиглэлээр гишүүн орнууд ажиллаж буйд бид ач холбогдол өгч байна. Түүнчлэн, гишүүн орнууд ойрын хугацаанд “Олон улсын автозамын тээвэрт таатай нөхцөл бүрдүүлэх тухай хэлэлцээр”-ийг байгуулахаар ажиллаж буйг Монгол Улс талархан хүлээн авч байгаа бөгөөд уг төсөлд зохих хэлбэрээр оролцох эрмэлзлэлтэй байгааг тэмдэглэе.

ШХАБ-ын хүрээнд хэрэгжүүлж буй олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож, үр шимийг нь ард иргэдийнхээ сайн сайхны төлөө зориулах нь бидний нийтлэг сонирхол билээ. Энэ хүрээнд өнөөдрийн хуралдаанаар батлаж буй “ШХАБ-ын гишүүн орнуудын урт хугацааны сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх 2013-2017 оны хөтөлбөр”-т Монгол Улс ач холбогдол өгч байгааг тэмдэглэе. Гишүүн орнуудын хэтийн төлөв, дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын талаарх хамтын үзэл санааг шингээсэн Бишкекийн тунхаглалд мөн анхаарал хандуулж байна. Төв Азийн бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх Афганистаны сэргээн босголтын үйл хэрэгт илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх ШХАБ-ын эрмэлзлэлийг Монгол Улс дэмжиж, хувь нэмрээ оруулахаар зохимжтой арга хэлбэрийг судалж байна.

Хатагтай, ноёд оо,

Азийн орнуудтай харилцаа хамтын ажиллагаагаа хөгжүүлж, бүс нутгийн интеграцид оновчтой хамрагдах нь манай гадаад бодлогын тэргүүлэх зорилт байсаар ирсэн. Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, интеграцийг түргэтгэж тогтвортой хөгжил бий болгоход Зүүн Хойд Азид аюулгүй байдлыг хангах явдал чухал юм. Энэ үүднээс бүс нутгийн орнуудтай хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, яриа хэлэлцээг идэвхжүүлэх зорилтын хүрээнд миний бие Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачлагыг дэвшүүлээд байна. “Улаанбаатарын яриа

хэлэлцээ” нь тус бүс нутагт аюулгүй байдал, тогтвортой хөгжил бий болгоход өөрийн хувь нэмрийг оруулахад чиглэх бөгөөд талуудыг яриа хэлэлцээнд оролцуулахад дэмжлэг үзүүлэхээс гадна бүс нутгийн эдийн засгийн интеграци, хүрээлэн буй орчин хамгаалал, уламжлалт бус заналхийлэл зэрэг өргөн хүрээтэй асуудлыг төрийн байгууллага болон эрдэм шинжилгээний /академик/ байгууллагуудын шугамаар таниулан, хамтран ажиллахад чиглэх юм.

Монгол улс гадаад бодлогодоо дэлхийн бүх улс түмэнтэй найрсгаар харилцаж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, мөн олон улсын асуудлуудыг шийдвэрлэхэд бололцооны хирээр өөрийн хувь нэмрийг оруулахыг зорьдог. Тэрхүү бодлогынхоо хүрээнд манай улс бүс нутгийн хамгийн том байгууллага, ШХАБ-ын гишүүн орнууд бүгд гишүүн нь болсон ЕАБХАБ-д элсч, бусад 56 гишүүн оронтой бүх чиглэлээр хамтын ажиллагаагаа хөгжүүлэхээр ажиллаж байна. Энэ утгаараа Монгол Улс нь Европ, Азийг холбосон бас нэг түүр болж байгааг энд дурдахад таатай байна.

Олон улсын харилцааны нэг түгшүүртэй асуудал бол өнөөдрийн Ази тивд орших Сири болон түүний эргэн тойронгийн асуудал болж байгаа талаар миний өмнө үг хэлсэн олон хүн цохон тэмдэглэсэн. Монгол Улс энэ асуудлыг эв зүйгээр, улс төр, дипломатын аргаар шийдвэрлэх явдлыг тууштай дэмжиж байна.

Хатагтай, ноёд оо,

Монгол Улс ШХАБ-ын гишүүн, ажиглагч орнууд, түүний дотор манай хөршүүд болох ОХУ, БНХАУ-тай дэд бүтэц, эдийн засаг, хөрөнгө оруулалт, худалдаа, дамжин өнгөрөх тээвэр зэрэг салбарын хамтын ажиллагааг харилцан ашигтай бүтээлчээр шийдвэрлэхэд онцгой анхаарч ирсэн. Манай улсын эдийн засгийн хүчин чадал нэмэгдэхийн хэрээр уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц зэрэг салбарт ШХАБ-ын гишүүн болон ажиглагч орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломж нэмэгдэж буйг тэмдэглэхийг хүсч байна. Энэ хүрээнд Монгол Улс дамжин өнгөрөх тээвэр, бусад дэд бүтцийн салбарт идэвхтэй хамтран ажиллахад бэлэн байгаагаа тэмдэглэе.

Бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, улс орнуудын хөгжил дэвшил, ард түмнүүдийн сайн сайхны төлөө ШХАБ, түүний гишүүн, ажиглагч, түнш орнуудтай Монгол Улс цаашид ч идэвхтэй хамтран ажиллах болно.

*Анхаарал тавьсанд баярлалаа.  
2013 оны 9 сарын 13. Киргиз улс*